



№08 (147)

2023 оны 08-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

ҮНДЭСНИЙ БӨХИЙН
БАРИЛДААН

2-р нүүрт

ҮНДЭСНИЙ СУРЫН
ХАРВАА

3-р нүүрт

2023 ОНЫ 7-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4-р нүүрт

2023 ОНЫ 7-Р САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ

5-р нүүрт

ҮНДЭСНИЙ ШАГАЙН
ХАРВАА

6-р нүүрт

ДЭЭЛТЭЙ МОНГОЛ
НААДАМ

7-р нүүрт

ХӨГЖӨӨНТ
БҮЖГИЙН ТЭМЦЭЭН

8-р нүүрт



Сонины
талаарх санал
хүсэлтээ
2125, 2602
дугаарын
утас, sxa@tpp4.mn эсвэл

СХА-нд файлаар болон бичгээр
өгч болно.



www.tpp4.mn/erchim

ЭРЧИМ ХҮЧНИЙ АЖИЛТНЫ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ

Монгол Улсад эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 101 жил, “ДЦС-4” ТӨХК-ийн 40 жилийн ой, Эрчим хүчний ажилтны өдрийг тохиолдуулан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажил хөдөлмөртөө өндөр амжилт гарган ажилласан 42 ажилтныг “ДЦС-4” ТӨХК-ийн “ХҮНДЭТ АЖИЛТАН” тэмдгээр, Эрчим хүчний салбарт олон жил идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа 42 ажилтныг Эрчим хүчний яамны “ЖУУХ БИЧИГ”-ээр, 60 ажилтанг “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” хүндэт тэмдгээр, Монгол Улсын санхүү, эдийн засгийн албыг бэхжүүлэх үйл хэрэгт олон жил үр бүтээлтэй ажилласан 5 ажилтныг “САНХҮҮ БАНКНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” цол, тэмдгээр, Төмөр замын

тээврийн салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж, “ХҮНДЭТ ТӨМӨР ЗАМЧИН” хүндэт тэмдгээр 3 ажилтныг, Нийслэл хотыг бүтээн байгуулж хөгжүүлэх үйлсэд өндөр амжилт гаргасан 8 ажилтныг Улаанбаатар хотын “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх үйл хэрэгт мэргэжлийн ур чадвар, хөдөлмөр бүтээлээ зориулж салбарын хамт олноо манлайлсан “НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” цол тэмдгээр 3 ажилтныг, Монголын залуучуудын холбооны “ТЭРГҮҮНИЙ ЗАЛУУ” алтан медалиар 6 ажилтныг, “ХӨДӨЛМӨРИЙН АЛДАР” медиалаар 4 ажилтныг, “ЗАЛУУ ҮЕИЙГ ХАЛАМЖЛАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ” тэмдгээр 5 ажилтныг тус тус шагнаж урамшуулав.





ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН

Компанийн түүхт 40 жилийн ойн үндэсний бөхийн барилдаанд нийт 64 бөх, үүнээс Аймгийн арслан-1, Аймгийн заан-1, Аймгийн начин-5, сумын заан-9, залуу бөх 48 зодоглож, 5-ын даваанд ДХХАЦ-ийн бөх аймгийн арслан Т.Сүрэнжав НАХ-ийн бөх аймгийн заан Энхзаяаг амлан, ЗЦ-ийн бөх аймгийн начин О.Бат-Эрдэнэ ЗЦ-ийн бөх сумын заан Б.Алтангэрэл нар тунан барилдсан.

Үзүүр түрүүнд аймгийн арслан Т.Сүрэнжав, аймгийн начин О.Бат-Эрдэнэ нар үлдэн барилдаж, ЗЦ-ийн бөх, аймгийн начин О.Бат-Эрдэнэ ДХХАЦ-ийн бөх аймгийн арслан Т.Сүрэнжавыг давснаар ЭХ-ний салбарын 101 жилийн ой, "ДЦС-4" ТӨХК үүсгэн байгуулагдсаны 40 жилийн ойн үндэсний бөхийн барилдаанд анх удаа түрүүллээ.



ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВАА



Монголын үндэсний сурын харвааны тэмцээнийг ТДЦ-ийн дарга П.Баяр-Эрдэнээр ахлуулсан 4 шүүгчийн бүрэлдэхүүнтэй баг 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Тэмцээний 1-р шатанд 20 багийн 40 харваач, үүнээс Сумын мэргэн -1, Улсын 1-р зэрэгтэй харваач - 1, залуу харваач - 38 оролцож, 2-р шатанд ТДЦ-ийн – 2, Хими цехийн – 2, Турбин цехийн -2, Зуухан цехийн -1, Механик цехийн-1 нийт 8 баг 2 дугаар шатанд шалгарсан.

2-р шатанд 8 багийн 16 харваач харваж Улсын 1-р зэрэгтэй харваач ТДЦ-ийн илчит тэрэгний машинч Т.Гэрэлтбаатар 4 сумнаас 4 онож, багийн гишүүн тоноглолын засварчин С.Энхтунгалаг 4 сумнаас 1 онож 50 оноогоор “Тэргүүн” байр эзэлсэн бол “Дэд” байранд

ТДЦ-ийн вагон хөмрөгчийн туслах машинч, Сумын мэргэн Я.Барамсай 4 сумнаас 2 онож, багийн залуу харваач удирдах щитний машинч Д.Батчимэг 4 сумнаас 2 онож нийт 40 оноогоор, “Гутгаар” байранд ХЦ-ийн тоноглолын засварчин залуу харваач О.Одбаяр, ус цэвэрлэгээний аппаратчин Э.Амарзаяа нар нийт 8 сумнаас тус бүр нэгийг онож 20 оноо авч ЭХ-ний салбарын 101 жилийн ой “ДЦС-4” ТӨХК үүсгэн байгуулагдсаны 40 жилийн ойн үндэсний сурын харваанд амжилттай оролцлоо.





2023 ОНЫ 7-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 3001,602 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 713,241 мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 2288,361 мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 325 МВт, дээд ачаалал 476 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	294.2	296.6	+2.4	100.8%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	160.5	160.5	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - 100,8%, ДЭХ - 100,0% биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
51	3001.602	42	1642.263	4	713.241	476	325	2288.361	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд 113,279 мян.кВтц буюу 6857,1 мян.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, 166,385 мян.кВтц буюу 8697,175 мян.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр 1,8 сая.төгрөгний алдагдалтай ажиллалаа. Өссөн дүнгээр 117,5 сая.төгрөгний авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс 14,0 сая.кВтц-аар давуулан 105,7%-н биелэлттэй, оны эхнээс 110,1 сая.кВтц-аар давуулж, 104,7% -ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 7-р сартай харьцуулбал 10,7 сая.кВтц буюу 4,4%-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт 2,3 мян.Гкал-аар тасарч 98,6%-н биелэлттэй, харин оны эхнээс нийт дулааны төлөвлөгөө 40,0 мян.Гкал-аар, үүнээс "УБДС" ХК -д нийлүүлэх дулаан 5,6 мян.Гкал -аар давсан үзүүлэлттэй байна. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 7-р сартай харьцуулбал 6,0 мян.Гкал буюу 3,9%-н өсөлттэй байлаа.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 7 зуух, 7 турбин оролцсон. Сарын дунджаар 4,2 зуух, 4,21 турбинтэй ажиллаж, 1 зуух, 1 турбин бэлтгэлд байлаа. Тайлант хугацаанд зуух 5 удаа, турбин 7 удаа зогссон.

Мазутын зарцуулалт

Энэ сард 120 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 189 тн-г түлж, 69 тн мазут хэтрүүлэн зарцуулсан.

Тайлант хугацаанд 7 удаагийн хүйтэн галлагаанд 187 тн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар 26 тн мазут зарцуулсан. Тайлант хугацаанд хэсэгчилсэн зогсолтоос 3 зуух галласан, 2/ҮИ өдөр зуух №5-г халуун бэлтгэлд оруулсан, зуух №1-г их засвараас галлах үед гэмтэл гарч галлагааг зогсоосон зэргээс мазутын зарцуулалт өссөн.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	140.000	147.669	+7.669	105.5%
Шивээ-Овоо	мян.тн	120.000	126.121	+6.121	105.1%
Бүгд	мян.тн	260.000	273.790	+13.790	105.3%

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: 1,196 гр/кВтц-аар, Дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: 0,006 кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс 310 тн жишмэл түлш буюу 688 тонн бодит түлш /илчлэг 3156 ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ -аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг 0,07%-иар буюу 210.555 мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	7-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	25.41	25.25
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.52	4.49
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.86	8.81
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.44	1.43
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.54	0.54

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнд барьж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт 9402 тн-оор нэмэгдсэн байна. Осмосын халаагч уурын зарцуулалт 3631 тн байлаа.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд: 40628 м³
- Зууханд: 658 м³ ус өгсөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт – 1676 м³ байлаа.



2023 ОНЫ 7-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 7-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 12 бүртгэгдсэнээс зуух 5 удаа, турбин 7 удаа зогссон.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар
1	Зуух	1	1	1	3	2	-	3	1	7	5
2	Турбин	1	1	-	2	2	1	1	3	4	7
Дүн		2	2	1	5	4	1	4	4	11	12

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоноглолын аварийн зогсолт судалсан акт: 3Ц-1 (0 ₮) Бүгд-1 (0 ₮)
- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЦЦ-1 (9.053.747 ₮), ТЦ-1 (0 ₮) Бүгд-2 (9.053.747 ₮)
- Мазут зарцуулалтын акт: 3Ц-1 (56.196.963 ₮), Бүгд-1 (56.196.963 ₮)
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ХА-1 (992857 ₮), Бүгд-1 (992857 ₮)

Нийт 5 ширхэг (66.243.567 төгрөг) акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °C)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	2022 оны 7-р сар	2023 оны 7-р сар	
1	ТДЦ	-	82.2	-	17.7	-	69.7	-	10.01	
2	ЗЦ	-	81.2	-	28.2	-	42.7	-	6.07	
3	ТЦ	-	78.3	-	26.1	-	45.8	-	-	Станцын дундаж тоосролт
4	ХЦ	-	75.1	-	28.1	-	43.7	-	-	
5	МЦ	-	89.1	-	23.7	-	54.7	-	-	

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр			
№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	72 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	56 ажлын байранд эргэлт шалгалтын маршрутын дагуу хяналт тавьсан.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	К-1-ийн дунд засвар, К-3-ын их засвар, ТГ-6-ийн их засварын ажилд хяналт тавьж байна.
2. Сургалт, зааварчилгаа			
1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	185 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	22 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	10 ажилтнаас шалгалт авсан.
3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар			
1	МХЕГ -ын ХАБУЛ лабораторитой байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	3-р улиралд хийгдэх шинжилгээнүүдийн нэхэмжлэх авсан гүйцэтгэх захиралаар зуруулж СБХ-т өгсөн.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн 6 цехд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийсэн.
3	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн.
4. Бусад ажлын талаар			

- Харшлаас хамтдаа сэргийлье уриа ажлыг зохион байгуулж МШӨ-ний үзлэг шинжилгээнд хамрагдсан хүмүүсийн бүртгэл хийсэн.
- Ажлын тусгай хувцас нэг бүрийн хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаа, хөдөлмөр хамгааллын нөөцийн зүйлд өөрчлөлт оруулж захирлын тушаал А/198 гаргуулж нэгжүүдэд түгээсэн.
- Хэсэгчилсэн зогсолттой хобоотой цехийн ХАБ-ын инженерүүд болон гэрээт компанийн ХАБ-ын инженерүүдтэй уулзалт хийж зааварчилгаа өгсөн.
- Баяр наадмын үед ХАБ-ын ханган ажиллах талаар нэгжүүдэд ээлжит бус зааварчилгаа өгөгдсөн байдалд хяналт тавьж шалгасан.
- ТАНЭБ-н Ерөнхий наряд №14,15-тай танилцаж наряд олгогчид зөвлөмж өгсөн.
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх ажлын байр, албан тушаалын жагсаалт гаргасан.
- ХАБ-ын 3-р улирлын III шатны үзлэгийн удирдамж гаргаж цехүүдэд түгээсэн.



ҮНДЭСНИЙ ШАГАЙН ХАРВАА

2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Түргэний голд эрчим хүчний ажилтан ажиллагсдын баярын өдөрлөг амжилттай зохион байгуулагдаж үндэсний хэв шинж, агуулгатай олон уралдаан тэмцээн ажилчдын дунд зохион байгуулагдлаа. Үүний нэг тэмцээн нь жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг үндэсний шагайн харвааны тэмцээн байлаа. Жил ирэх тусам энэ наадгайгаар хичээллэгчдийн тоо нэмэгдэж түүнийгээ дагаад чанар чансаа улам ахиж байгаа нь сүүлийн 2 жилийн үр дүнгээр харагдаж байна. Энэ жилийн хувьд харваач тус бүр нийт 20 сум харваж хамгийн олон оносон эхний 5 байрыг шалгаруулахад 14 оноогоор Цахилгаан цехийн харваач Б.Даваадорж тэргүүн байр эзэлсэн бол 2022 оны аварга Цахилгаан цехийн харваач О.Тэмүүжин дэд байранд 13 оноогоор шалгарлаа. Гутгаар байранд Түлш дамжуулах цехийн харваач Ү.Болд 9 оноогоор шалгарсан бол тусгай байруудад Дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн харваач С.Сүхбат 8 оноогоор, Хими цехийн харваач Б.Алтанбагана 7 оноогоор удаах байруудад шалгарлаа. Энэ жилийн хувьд нийт 32 харваач өрсөлдсөн нь сүүлийн жилүүдэд компанийн хэмжээнд үндэсний шагайн харваагаар хичээллэгчдийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь харагдаж байна.



ДЭЭЛТЭЙ МОНГОЛ

Эрчим хүчний салбарын 101 жилийн ой, “ДЦС-4” ТӨХК-ийн үүсгэн байгуулагдсаны 40 жилийн ойтой холбогдуулан Эрчим хүчний ажилчдын баяраар “Дээлтэй Монгол” загварын уралдаан зохион байгууллаа.

Уралдаанд ТДЦ, ЗЦ, ХЦ, МЦ, СХА, БМА, СБХ, НАХ, ЭЗЦГ идэвхтэй хамрагдан оролцлоо. Тус тэмцээнд 13 хос 26 хүн халх, буриад, казах, үзэмчин төрлийн өмсгөл хувцасаар өрсөлдөж ТДЦ, ЗЦ, МЦ-ээс оролцсон үзүүлбэрүүд эхний байруудыг эзэлсэн байна. ТДЦ 3 хос оролцож халх, казах үндэсний хувцасаар тэргүүн байранд шалгарлаа.

Тэргүүн байр эзэлсэн ТДЦ-ийн 3 хос

Овог нэр	Нэгж, албан тушаал	Хувцас танилцуулга
М.Сүлейман	ТДЦ ХӨЗМ-н мастер	Казах
Ж.Бейбитгүл	ТДЦ Дамжлагийн машинч	Казах
Э.Бимэдэхгүй	ТДЦ Тоноглолын засварчин	Халх

Б.Ариунгэрэл	ТДЦ Дамжлагийн машинч	Халх
Н.Балжинням	ТДЦ Илчит тэрэгний машинч	Халх
Э.Дариймаа	ТДЦ Ачаа вагон хүлээлцэгч	Халх

2-р байр- Зуухан цехийн хос

Овог нэр	Нэгж албан тушаал	Хувцас танилцуулга
О.Батбилгүүн	ЗЦ-ЗБТБ засварчин	халх
Г.Хажидмаа	ЗЦ-туслах тоноглолын машинч	халх

3-р байранд Механик цехийн хос

Овог нэр	Нэгж албан тушаал	Хувцас танилцуулга
Б.Мөнхзул	МЦ токарчин	халх
И.Ариунжаргал	МЦ – Өрөмийн тоноглолын машинч	халх





“ХӨГЖӨӨНТ БҮЖГИЙН” ТЭМЦЭЭН

Эрчим хүчний салбарын ажиллагсдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх энэ удаагийн баяраар Залуучуудын холбооноос Хөгжөөнт бүжгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд нийт 8 баг /7 цех 1 захиргаа/, тус бүр 15-аас дээш хүний бүрэлдхүүнтэйгээр өгөгдсөн 5 аян дээр бүжиглэж аваргаа шалгарууллаа.

Тэмцээний 1-р байр Турбин цех, 2-р байр Хими цех, 3-р байр ТДЦ-ийн багууд эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Тэмцээнийг 5 шүүгч шүүн явуулсан бөгөөд 1-3 оноогоор багуудын оролцоо, бүжгийн дэглэлт, тайзны соёл гэсэн 3 үзүүлэлтийг дүгнэж шүүлээ.

